



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/71/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	“Тэд-Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Ц.Сугармаа Утас: 99151254 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com Аудит менежер: В.Оюунчимэг Утас: 99190483 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com Ахлах аудитор: Н.Дэлгэрмаа Утас: 99244686 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com
-----------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 488

танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН УСАН
СПОРТ СУРГАЛТЫН ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.ТУЯА
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэн нийлэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар дээрх нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын барилга нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж Нийслэлийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 421 дүгээр захирамжийг үндэслэн өөрийн эзэмшлийн хөрөнгөөр бүртгэгдсэн бөгөөд тухайн үед газрын бүртгэлийн асуудлыг нь шийдээгүйгээс барилгын доорх 1200,0 м² газар нь нийслэлийн 21 дүгээр сургуулийн эзэмшилд байдаг тул одоог хүртэл маргаантай, шийдвэрлэгдэхгүй явж ирсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 1 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 99.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
МӨРИЙН ДУГААР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	37,801,489.29	30,884,994.29
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	6,642,087.06	2,708,481.10
1.1.4	Бусад авлага	200,000.00	-
1.1.6	Бараа материал	45,065,486.23	45,036,665.58
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	278,299.52	392,029.52
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	89,987,362.10	79,022,170.49
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,280,877,302.43	1,231,789,862.53
1.2.2	Биет бус хөрөнгө	2,793,560.51	1,873,105.91
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,283,670,862.94	1,233,662,968.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,373,658,225.04	1,312,685,138.93
2.1.1.3	Татварын өр	11,366,582.53	3,206,396.97
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	710,171,640.36	654,634,157.40
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	289,134.45	203,076.75
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	731,400,858.14	658,043,631.12
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	731,400,858.14	658,043,631.12
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	432,607,829.66	432,607,829.66
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	209,649,537.24	222,033,678.15
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	642,257,366.90	654,641,507.81
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	1,373,658,225.04	1,312,685,138.93

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
МӨРИЙН ДУГААР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Борлуулалтын орлого /цэвэр/	448,877,687.47	400,018,031.08
3	Нийт ашиг (алдагдал)	448,877,687.47	400,018,031.08
8	Бусад орлого	55,537,482.96	55,537,482.96
10	Ерөнхий ба удирдлагын зардал	387,593,179.64	433,938,035.45
12	Бусад зардал	14,964,983.63	9,171,105.82
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(1,480,621.30)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	100,375,655.86	12,446,372.77
19	Орлогын татварын зардал	730,750.27	62,231.86
20	Татварын дараах ашиг (алдагдал)	99,644,905.59	12,384,140.91
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	99,644,905.59	12,384,140.91
24	Орлогын нийт дүн	99,644,905.59	12,384,140.91

2.3. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ДУГААР	ҮЗҮҮЛЭЛТ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ ДҮН
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	432,607,829.66	109,867,538.01	542,475,367.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	136,363.64	136,363.64
3	Залруулсан үлдэгдэл	432,607,829.66	110,003,901.65	542,611,731.31
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	99,645,635.59	99,645,635.59
9	2022 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	432,607,829.66	209,649,537.24	642,257,366.90
11	Залруулсан үлдэгдэл	432,607,829.66	209,649,537.24	642,257,366.90
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		12,384,140.91	12,384,140.91
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	432,607,829.66	222,033,678.15	654,641,507.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

МӨРИЙН ДУГААР	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1.1	Мөнгөн орлогын дүн	497,190,172.37	448,917,599.20
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	448,877,687.47	399,987,592.51
1.1.6	Бусад мөнгөн орлого	48,312,484.90	48,930,006.69
1.2	Мөнгөн зарлагын дүн	453,839,822.84	452,639,003.29
1.2.1	Ажилчдад төлсөн	169,753,462.78	198,982,469.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,161,643.76	28,895,366.58
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	29,971,640.91	29,331,348.84
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	61,166,705.65	74,703,639.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	1,715,154.50	1,355,454.47
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	67,169,140.41	49,872,114.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	279,018.18	282,920.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,623,056.65	69,215,688.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	43,350,349.53	-3,721,404.09
2.2	Мөнгөн зарлагын дүн	5,618,863.64	3,195,090.91
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,073,409.09	3,195,090.91
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,545,454.55	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,618,863.64	-3,195,090.91
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	37,731,485.89	-6,916,495.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,003.40	37,801,489.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,801,489.29	30,884,994.29

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,625.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, 4,625.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээл-лийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд зардал дутуу илэрхийлсэн	1	4,625.0			1	4,625.0	1	4,625.0				
Дүн	1	4,625.0			1	4,625.0	1	4,625.0				

Аудитаар нийт 2 зөрчил² илэрснээс 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй	1	-					1	-				
Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж баталгаажуулж, тайлагнаагүй	1	-					1	-				
Дүн	2	-					2	-				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.